

# ЗАВХАН АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



# ЗАВХАН

## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

1931 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Хантайшир уулын аймгийг татан буулгаж Завхан аймгийг байгуулах шийдвэр гарсан. Хантайшир уулын аймгийн Нөмрөг уулын хошуу /Хуучин Засагтхан аймгийн Цогтой вангийн хошуу/, Цэцэн сартуул хошуу /хуучин Засагтхан аймгийн Цэцэн сартуул вангийн хошуу/, Гурван Сайхан Жаргалант/ хуучин Засагтхан аймгийн Баатар вангийн хошуу/, Цэцэрлэгмандал уулын аймгийн Отгонхайрхан уулын хошуудаас /хуучин Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн засгийн хошуу/ анх Завхан аймгийг байгуулжээ.

Аймгийн төв: Улиастай хот

Хэдэн сумтай: 24

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 82,455.66 км<sup>2</sup>

Хүн ам: 72,823 (2020 он)

Угсаатан: Халх

Малын тоо толгой: 3,607,840 (2020 он)

Утасны код: +976 (0)146

Шуудангийн дугаар: 81000

ТХ-ийн улсын дугаар: 3А

Цахим хуудас: [www.zavkhan.gov.mn](http://www.zavkhan.gov.mn)

Завхан аймаг эх орныхоо баруун хойд хэсэгт буюу Хангайн нурууны өндөрлөгийн баруун хэсэг, Их нууруудын хотгорын зүүн, Монгол Алтайн нурууны салбар уулсын хойд хэсэгт оршдог. Завхан аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны дундаж өндрөөс 500 метр орчим илүү өндөрлөг газар байрлана. Аймгийн нутаг зүүнээс баруун тийш намсаж тогтжээ. Хангайн нурууны ноён оргил 4031 метр өндөр Отгонтэнгэр уул, хамгийн нам цэг Дөргөн нуурын хөвөөнд хилийн цэг 1132 метр далайн түвшнээс дээш 2000 метрт оршдог нь Төв Азийн уулархаг сэрүүн бүсэд хамарч, хур, чийг багатай хангай, хээр, говь хосолсон нутаг юм. Аймгийн нутагт Их нууруудын чиглэлийн Монгол элс, дунд хэсгээр Бор хярын элс, өргөргийн дагуу баруунаас нийт нутгийн 50 орчим хувьд түрж орсон байх ба хойд хилийн дагуух Тэсийн голд тармацаг элстэй байдаг.



# УЛИАСТАЙ

ХОТЫН ТУХАЙ



1733 онд Зүүнгарын Галданцэрэнгийн цэргээс сэргийлэн “Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин”-ы газрыг байгуулсныг Улиастай хотын үүсэл гэж үздэг. XX зууны эхэнд Улиастайн ойр орчим нутаг нь Дашпунцаглин хийдийн эзэмшил бөгөөд Сайн ноён аймагт харьяалагдаж байсан байна. БНМАУ-ын Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор 1931 оны 2 дугаар сарын 18-нд Хан Тайшир уулын аймгийг татан буулгаж Завхан аймгийг шинээр байгуулж, Жавхлант хотод төвлөсөн. Жавхлант хотыг 1961 онд Улиастай хот хэмээн хуучин нэрээр нэрлэх болжээ.

Өрхийн тоо: 4,837 (2020 он)

Хүн амын тоо: 16,232 (2020 он)

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 1115 км

# ЗАВХАН АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

## Отгонтэнгэр орчмын байгаль, Улиастайн шашин, соёлын аялал жуулчлалын бүс

*/Байгаль, түүх, шашин мөргөлийн аяллын төрөлд хамаарна/*

### **Чиглэл нь:**

Улиастай - Богдын гол, хүрхрээ - Усан цахилгаан станц - Отгонтэнгэрийн халуун рашаан ус - Даян хайрхан - Цагаан нуур - Хөх нуур - Долоогийн даваагаар Ширээгийн гол – Отгон сум – Буянт баг - Очирваань хөшөө - Бадархундага нуур, Отгонтэнгэр хайрхан - Отгон сум - Дааган дэлийн буган чулуу - Цагаанхайрхан - Алдархаан сум - Явуухулангийн бууц - Тэхийн зогсоол - Донойн хөндий - Жавхлант толгой - Улиастай.

## Тарвагатай нурууны байгалийн аялал жуулчлалын бүс

*/Байгалийн аялал жуулчлал/*

### **Чиглэл нь:**

Солонготын даваа - Зартын рашаан - Солонготын давааны төв зам - Цэцүүхийн булш, хиргисүүр - Их уул сум - Гүнжийн хясаа - Тосонцэнгэл сум - Дугуй мод - Хожуулын гол - Марцын рашаан - Баяжихын даваа - Бөхөн шарын даваа - Дэл хадны зураг - Идэр сум - Ялгуусан хутагтын хийд - Цагаан нуур – Идэр сум - Замбага жуулчны бааз, Долоон товгор элс - Тэлмэн - Дөрвөн замын уулзвар - Тосонцэнгэл - Их уул - Солонготын даваа

## Хил орчмын аялал жуулчлалын бүс

*/Байгалийн аялал жуулчлал/*

### **Чиглэл нь:**

Дөрвөн зам - Тэлмэн нуур - Нөмрөг сум - Холбоо нуур - Хунт нуур - Бүст нуур - Баянзүрхийн рашаан ус - Асгат сум - Баянтэс сум - Зайгал баг - Зайгалын шугуй - Жавхлант баг - Аажаа гэгээний туурь - Тэс сум - Сүмтийн цайзын туурь - Тэсийн шугуй - Элстэйн рашаан ус - Баянхайрхан сум - Ойгон нуур - Түдэвтэй сум – Нөмрөг сум – Дөрвөн замын уулзвар

## Хар нуур орчмын аялал жуулчлалын бүс

*//Нутгийн иргэдэд түшиглэсэн, соёл, байгалийн аялал/*

### **Чиглэл нь:**

Улиастай - Ганц худагийн даваагаар Хаг нуур - Яруу сум – Мөсөн баг – Алтан баг – Хар нуур - Сэнжит хад - Мухартын гол – Эрдэнэхайрхан сум - Гацаа болон Бор хярын элс - Завханмандал сум – Талын гурван улаан – Ургамал сум – Баян нуур - Буга согоотын буган чулуун хөшөө (Дуут чулуу) – Сантмаргац сум – Цэцэн уул сум – Арслан чулуу - Сангийн далай баг - Яруу сум – Загастайн давааны Улаан хаалгын хүн чулуу – Улиастай

# ҮЗМЭРҮҮД

## ЗАВХАН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### ОТГОНТЭНГЭР ХАЙРХАН

Монголчууд энэ хайрханаа эртнээс тахиж шүтэж ирсэн ба анх 6-8р зуунд Түргүүд тахидаг байжээ. Түүнээс хойш 1779 онд сэргээн тахиж байгаад мартагдан 1911онд Богд хаан жил бүр ламын шашины ёсоор тахиж байж байгаад мөн мартагдан 1995 онд төрийн тахилгатай болж 4 жилд нэг удаа тахидаг уламжлал тогтсон байна. Энэ хайрхан нь эргэн тойрон битүү ой хөвч, ширүүн урсгалт, нуураар элбэг ойр орчмын уулсууд байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрууд, ан амьтан биосфер, экосистемийн бүрдэл маш сайн бүрдсэн, ховор ургамал амьтан элбэг, олонд алдаршсан рашаан сувилал, хойд талаас нь эх авч урсах Богдын голын баруун эрэгт байдаг. Завхан аймгийн Отгон, Цагаан хайрхан, Алдархаан, сумдын нутгийн заагт оршдог Аймгийн төвөөс Отгоны амралт хүртэл 78 км, Отгон сумаас Хайрханы өвөр Бадархундаг нуур хүртэл 65 км байдаг байна. Хангайн нурууны Ноён оргил Отгонтэнгэр уулыг "Богд Очирваань" хайрхан хэмээн хүндэтгэн нэрлэдэг. Отгонтэнгэр уулыг онгоцоор нар зөв тойрч харахад яг л жанчаа нөмрөөд заларч суугаа Очирваань бурхны дүр харагдаж байдаг ажээ. Газар зүйн судалгаанаас үзвэл Отгонтэнгэр уулыг Дундад Азийн хамгийн отгон галт уул гэж үздэг. Очирваанийг тойрсон 8 цэнгэг нуур буй. Эдгээр нуурууд нь найман бэлгэдэл ажээ. Отгонтэнгэр хайрханы зүүн бэлд баруун өмнө зүг чиглэн аварга том яст мэлхийн хэлбэр бүхий харлаг хад бий.



# ҮЗМЭРҮҮД

## ЗАВХАН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ҮР ХАЙРЛАХ ШИДТЭЙ ДАЯН ХАЙРХАН**

Отгон тэнгэрийн баруун талд харуул мэт сүндэрлэх Их даян, Бага даян гэсэн далайн түвшнээс 2500 метрийн өндөртэй хоёр сүрлэг хайрхан бий. Даянгийн хоёр талд хөх, Цагаан гэсэн хоёр нуур байх ба энэ ууланд Отгонтэнгэрийн бүсийн ховор ургамал болох вансэмбэрүү, хонин арц, алтан гагнуур, жамъянмядаг зэрэг эмийн бусад ховор ургамалтай. Орой дээрээ хэсэг хавтгай газартай ба голд нь тайхар чулуу байдаг. Уулын дээрээс тэртээд харагдах Алтайн хөх уул, Монгол элс зэрэг ойр орчмын өндөр хайрхан уулсууд алган дээр тавьсан мэт үзэсгэлэнтэй харагдах нь эртнээс нааш нутгийн ард түмэн Даян хайрхан дээрээс дэлхий харагдана гэж ярьцгаадаг байна. Мөн бөөгийн шашинд энэ хайрханы дэргэд эр эм хоёр мөргөл залбирал үйлдэж сүслэвээс үр хүүхэд заяадаг домтой, баатар хөвүүн заяадаг ч хэмээдэг. Цагаан нуур нь Даян хайрханы баруун бэлд хөх нуураас холгүй 2230 м өндөрт оршдог, Морены хурдсанд хөөгдөж тогтсон Цэнгэг устай 3.1 км.кв талбайтай, 3.6км урт, 1.6км өргөн гүн нь 28м, Их бага даян хайрханд тулж хошуу хойг булан тохой үүсгэх тул эргийн хэрчигдэл ихтэй, урт нь 12км , өмнөөс нь нуурын хоолой хэмээх гол хэдэн булгийн хамт цутгадаг.



# ҮЗМЭРҮҮД

## ЗАВХАН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ХАР НУУР**

Эрдэнэхайрхан сумын төвөөс зүүн хойш 80 км, Аймгийн төвөөс 110 км оршдог. Хойд талаараа элсэн манхан, элсэн шанаагаар хүрээлэгдсэн, урд талаараа эрэг орчмын шанаанууд зэгстэй жаахан нуур Товхошийн сүрлэг уулаар хүрээлэгдсэн байдаг. Гүнээрээ 48 м, уртаашаа 30 орчим км, өргөн нь 5-10 км сунаж тогтсон нуур омель, пельд загас үрждэг бөгөөд нуурын голд далайн түвшнээс дээш 2600м өргөгдсөн их, бага 2 авгаш байдаг. Нуур нь хойд талаараа элсээр хүрээлэгдсэн Хангайн сувд гэгддэг нуур. Урьд талаараа Товхош, Намаржаа, Хар хад гэсэн өндөр уулсаар хүрээлэгдсэн. Энд 13 төрлийн нүүдлийн шувууд ирдэг. Мөн нуурын дээгүүр шунх хэмээх цэцэг ургаж гарч ирсэн нь сайхан үзэсгэлэнтэй харагддаг. Нуурын ус баруун өмнөөс хүрээлсэн манхан элсэн доогуур шурган, 10 гаруй булаг болон ундрэн шүүрч, Хүнгүйн голд нийлэх учраас ийнхүү давсгүй хужиргүй байдаг онцлогтой.



# ҮЗМЭРҮҮД

## ЗАВХАН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ЗАГАСТАЙН ДАВААНЫ ХҮН ЧУЛУУ**

Эрт урьд цагт Монголчууд хятадад ноёрхож байхад юм гэнэ. Хятадууд бослого гарган Монгол хааны аминд хүрээд зогсохгүй үр удмаар нь хүйс тэмтрэх хорон санаа өвөрлөжээ. Хааны эхнэр нэгэн ламын туслалцаатайгаар Чингис хааны хойчийг залгамжлах бяцхан нуган үрээ аван санд мэнд зугтаж амжиж гэнэ. Босуул гурав тэмээ унан говь цөлийг туулан эх Монгол нутгаа тэмцжээ. Хятад түшмэд тэднийг барьсан хүнд их хэмжээний шагнал амлан 300 морьтон цэрэг илгээн тэдний араас мөрдүүлж гэнэ. Хөөн ирсэн дайсанд гүйцэгддэгийн даваан дээр лам тэнгэр бурханд залбиран хур гуйсанд их цас орж морь унасан хятад цэрэг урагшилж үл чадан ард хоцорчээ. Ийнхүү тэд явсаар Загастайн даваанд дөхөж байтал мөрдөн хөөгчид дахин ойртож иржээ. Оргодол гурван Монголын толгойг тасдан аваачиж өндөр шан хүртэхийг горьдсон хятадуудын баясан хашгирах дуу араас нь улам ойртсоор л. Гэтэл давааны оройд гараад тамир нь барагдсан ламтан үхэдхийн унаж бурхны оронд оджээ. Яахаа мэдэхээ байсан залуу хатан бяцхан хүүгээ дээш өргөн “Монгол газрын этүгэн эх дэлхий, бурхад минь ээ! Монгол хэмээх нэрийг даян дэлхийд цууриатуулсан агуу их хүний удмыг энэрэн соёрхож хайрла! Чингис хааны яс махны тасархайг үхлээс хэлтрүүлж соёрхооч! гэж гуйн хашгирсан байна. Тэгтэл түүний хажууд нэгэн бяцхан цагаан хулгана гарч ирээд хүний хэлээр намуухан дуу гарган: “Чамайг авруулахаар намайг илгээсэн болой.



# ҮЗМЭРҮҮД

## ЗАВХАН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **БОР ХЯРЫН ИХ ЭЛСЭН МАНХАН**

Баруун Зүүн Монгол хэмээх хоёр уулын өмнөхөн байдаг бөгөөд Завхан аймгийн Ургамал сумын араар зүүн тийш үргэлжлэн, Хунгийн голыг хөвөөлдөг. Тэндээс Эрдэнэ хайрхан сумын хойгуур өгсөж, Яруу нутаг хүртэл тэлж тариан шаргал үтрэм шиг санагдах 300 орчим км урт үргэлжилнэ. Эл манхан элсийг хөндлөн туулах Монгол хотгор. Олгой, Цэцэний сүв гэж бий. Элсэн манхан далай болсон энэ алтан шижир элсийг ирээдүйн Монголын барагдашгүй алтан чулууд гэж нутгийн олон хэлцдэг.

Мухартын гол: Уг гол нь Эрдэнэ хайрхан Сумын төвөөс зүүн хойд зүгт Бор хярын элсний өмнө талд далайн түвшнээс дээш 450м өндөр элсэн манханаас эх авч урсдаг, хөвөөгөөрөө бургасан шугуйтай, гоньд, дэгд, улаалзгана, нохойн хошуу зэрэг жимс жимсгэнтэй байгалийн өвөрмөц тогтоц бүхий цогцолборт газар



# ҮЗМЭРҮҮД

## ЗАВХАН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ИХ ХАЙРХАН УУЛ**

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт байх, эртний далайн ёроол бүхий тогтоцтой, шохойн чулуун уулыг Их Хайрхан уул хэмээдэг. Уг уул цавчим өндөр байц хад бүхий хавцлуудтай, 10-15 метр урт аж. 108 хадан агуй, төрөл бүрийн модлог бутлаг ургамал, олон зүйлийн ан амьтантай, унаган төрхөө жинхэнээр нь хадгалсан байгалийн үзэсгэлэн бүрдсэн энэ уулыг зоригсдын тоо жилээс жилд нэмэгдсээр буй аж. Нутгийн ард иргэд ч уг уулыг Манзушир бурхны орон буюу Алтан тэвш уул хэмээн хүндэтгэн нэрлэж тахин шүтсээр иржээ. Түүний 108 агуйн дотроос хамгийн том нь Эхийн, Намширын, Бага гэж нэрлэгддэг агуйнууд юм. Эхийн агуй нь 137 метр урт бөгөөд агуйн аман дээр хадаг яндар бүхий том овоо босгосон байдаг. 70 орчим метр газрыг босоогоор явж, цаашлах тусам бөхийж, мөлхөж явсаар мухарт хүрэх ба агуйн адагт сэндэр шороо байх аж. Энэ шороог эртнээс нааш Монголчууд яр шарханд түрхэх байдлаар хэрэглэж ирсэн аж. Эхийн агуй нь Их Хайрхан уулын баруун хойд аманд оршино. Эхийн агуйн аманд хадаг яндар бүхий том овоо байна. Мөн агуйд ирсэн хүмүүс нэр ус, хаягаа үлдээдэг жижиг дэвтэр бий. Агуйд орохдоо лаа болон бамбар хийж ордогтой холбоотойгоор агуйн хана, адар тортог болсон байна. Их Хайрхан ууланд агуй үзэхээс гадна Хайрханы байгалийн өвөрмөц тогтоц ханан хад цохионууд нь үнэхээр гайхамшигтай байдаг.



# ҮЗМЭРҮҮД

## ЗАВХАН АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

### **ДУУТ ЧУЛУУ**

Завхан аймгийн Сантмаргац суманд байдаг. Сумын төвөөс Зүүн хойно 23 кмт байдаг. Уг дурсгал нь одоо байгаа төрхөөрөө дуут буюу дэрэн чулуу гэж нэрлэдэг. Учир нь 3ш жижиг чулуун дээр хар хөх чулууг хэвтээгээр нь байрлуулсан, чулууны хэмжээ нь урт нь 85см, өргөн нь 55см, зузаан нь 32см ба чулууны дээд хэсэгт 23 хонхор цэгэн тойргон бүслүүртэй, хоёр хажуу талд яг ижил хэмжээтэй дугуй хэлбэрийн хонхойлгож дүрсэлсэн нь МЭӨ 3000 жилийн үеийн хүрлийн үеийн буган чулуу. Уг чулууны нэг онцлог нь мод чулуугаар цохиход яг хөндий төмөр шиг дугардаг байна.



# БУСАД ҮЗМЭРҮҮД



## ДОЛООН ТОВГОР

Тэлмэн сумын төвөөс 20 км оршдог үзэсгэлэнтэй сайхан элсэн уул бөгөөд бүх төрлийн мод, бут сөөг ургадаг, уулын бэлээс өвөл хөлддөггүй хүйтэн рашаан ундардаг, рашааны ундаргыг дагасан хангайн байдлыг санагдуулам битүү ногоон мод, жимс жимсгэнэ, ан амьтантай. Уулаас зүүн урд талд долоон товгор элсэн манхан байдаг. Үүний хоёр манханы орой дээр Замбага цэцэг ургадаг. Маш нарийн ширхэгтэй, уусдаг элстэй. Манханы хойд талд үзэсгэлэнт Ангирт нуур оршдог.

## ЦАГААН НУУР

Даян хайрханы баруун бэлд Хөх нуураас холгүй далайн түвшнээс 2230 м өндөрт оршдог. Морены хурдсанд хөөгдөж тогтсон цэнгэг устай 3.1 км.кв талбайтай, 3.6км урт, 1.6км өргөн гүн нь 28 м нуур юм. Их бага Даян хайрханд тулж хошуу хойг булан тохой үүсгэх тул эргийн хэрчигдэл ихтэй, урт нь 12км, өмнөөс нь нуурын хоолой хэмээх гол хэдэн булгийн хамт цутгадаг.

## НОГООН НУУР

Овоот уулын бэл. Тусгалтын ар бэлээр урссан Идэр голын зүүн талд байрлаж төгссөн нуур. Ногоон нуур гэсний учир нь Овоотын өвөрт байгаа эрдэнийн туяа энэ нуурт туссанаас нуурын ус ногоон харагддаг гэсэн домог яриа байдаг. Нуурын ус нь аль ч талын эргээсээ дотогш 5-8м орчмын зайд хар харагдаад үүнээс цааш ногоон өнгөтэй харагддаг. Энэ нь эргэн тойрны ногоон ой модны тусгал байж болох юм. Хажууд нь очиход нуурын ус нь маш тунгалаг бөгөөд дотор нь явж буй загас тод харагддаг байна. Нуурын эргээс ус байнга шүүрч усны түвшингөө хадгалдаг ба нуураас жижиг цутгал урсан гарч Идэр голд нийлдэг байна.



# БУСАД ҮЗМЭРҮҮД

## БОГДЫН ГОЛЫН ХҮРХРЭЭ

Завхан аймаг тогтмол цахилгаангүй, хязгаарлалттай ажиллуулдаг дизелийн мотороор гэрэл залгуулж байлаа. 1994 онд Монгол инженерүүд Алдархаан сумын нутаг дахь түргэн урсгалтай Богдын гол дээр бага оврын усан цахилгаан станц (УЦС) байгуулжээ. Энэ станцын суваг, хоолойг 2005 онд Германы буцалтгүй тусламжийн хөрөнгөөр засварлаж үйл ажиллагааг нь сайжруулснаар Улиастай хотынхон зундаа цахилгаанаар тасрахгүй, өвөлдөө Тайширын УЦС-тай холбогдох болжээ. Аймгийн төвөөс зүүн урагш 36 км зайд орших, 2 мегаваттын чадалтай энэ УЦС-ын техникийн шийдэл их өвөрмөц ажээ. Богдын голын өндөр хясаатай нэгэн эргэлт дээр 2.5 км-ын алсаас салаалан суваг татаж, усыг нь тойруу замаар урсгалын хүчээр нь урсган, бага багаар өгсүүлсээр өндөр толгой дээрх усан санг дүүргэж байна. Толгойн цаад талын огцом уналттай налуу дээр хоёр том хоолой уруудан байрлуулж, бэлд нь турбин тавьж цахилгаан үйлдвэрлэж байна. Толгойн зүүн хажуу болох 17 метрийн өндөр хясаанаас хальсан усаа унагаснаар хүний гараар бүтээсэн хүрхрээ бий болж, байгалийн бас нэг хосгүй үзэсгэлэнг бүрдүүлжээ.



## ТЭНГЭРИЙН ҮҮД ХЭМЭЭГЧ СЭНЖИТ ЦОХИО

Нутгийнхан Тэнгэрийн үүд хэмээн шүтэх Сэнжит цохио нь Эрдэнэхайрхан сумын төвөөс зүүн хойд зүгт оршдог. Далайн түвшинөөс дээш 2773 метрийн өндөрт өргөгдсөн байна. Энэхүү сонин тогтоц бүхий цохио нь элсэн манхан бүхий уулын оройд 10 метрийн өндөр, 6-8 метрийн өргөн, боржин чулуун байгалийн хаалга мэт өвөрмөц тогтоцтой, ойр орчмын үзэсгэлэнт газар элбэгтэй аж. Тэнгэрийн үүдийг зорих хэн бүхэн мосттой тээврийн хэрэгслээр гарч болох ба цааш давж 30 км яваад Улаагчны Хар нуурын үзэсгэлэнт газар луу орж үзэж болох юм.



## ОЙГОН НУУР

Засагт хан аймгийн Нөмрөг уулын Загдсамбарын хошуу одоогийн Завхан аймгийн Түдэвтэй сумын Ойгон багийн нутагт эртний домогт Ойгон нуур эргэн тойрондоо 108 том жижиг нуураар хүрээлүүлэн оршдог нь байгалийн үзэсгэлэнт зүй тогтоц юм. Ойгон нуурын арын "Баян-Айраг" уулын өвөрт "Түшлэгийн булаг" "Их намаржаа" нуурын урд хөндий "Бугын толгойтын эх" хэмээх газруудад Монгол Улсын төрийн тамгат "Дилав", "Жалханз", Арь гэгээн хэмээх хутагтууд төрөн гарч нэгэн эрин үеийн төрийг түшилцэж байсан түүхтэй. Ойгон нуурын тухай олон домог байдаг. Энэ нуурын лусын эзэнг эмэгтэй хүн гэж үе дамжин яригдсаар ирсэн билээ. Идэр есийн хүйтэнд гэрийн буйрны чинээ хөлдөөгүй хоёр дугуй байдаг ч гэж ярьдаг Үүнийг нь нуурын өрх гэж нэрлэж ирсэн түүхтэй. Нуурын ар биед нь "Алтан тэвш" гэж хонхор байдаг боловч тэр бүр хүнтэй таардаггүй. Таарсан хүн дотор нь орж хэвтвэл арын үргэлжилсэн "Баян-Айраг" уулын хамгийн өндөр цэг болох "Тугч"-ийн орой л харагддаг гэж өвгөд хөгшид ярьдаг юм. Хэрвээ хүн таарвал том аз завшаан гэж үзэн дотор нь орж хэвтвэл маш ихээр баяждаг гэж үр хүүхэд дээ захидаг уламжлалтай.



# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД

## ХАР НУУР ОРЧМЫН БААЗУУД

©BatayaPhotography



### ХАР НУУР

📍 Завхан аймгийн  
Эрдэнэхайрхан сум

☎ 99147409

🌐 <https://zavkhan.travel/camp/>

📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ИХ ТЭНГЭРИЙН ХҮРЭЭ

📍 Завхан аймгийн  
Эрдэнэхайрхан сум

☎ 98114787

🌐 <https://zavkhan.travel/camp/>

📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E



### ЗАМБА ТУР

📍 Завхан аймгийн  
Эрдэнэхайрхан сум

☎ 88917732

🌐 <https://zavkhan.travel/camp/>

📄 lounge.resistors.showroom  
46.2729° N, 102.7790° E

# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД



## УЛИАСТАЙ ХОТЫН ЗООГИЙН ГАЗРУУД



### ЗАГАСАН НҮД

📍 Завхан аймгийн  
Улиастай хот

☎ 99463000

📌 Монгол, Европ, Ази хоол  
<https://zavkhan.travel>

📏 сүлжээ.ангиан.ухаантан  
46.2729° N, 102.7790° E



### ӨРГӨӨ

📍 Завхан аймгийн  
Улиастай хот

☎ 99469933

📌 Монгол хоол  
<https://zavkhan.travel>

📏 нотолгоо.ивээх.цоож  
46.2729° N, 102.7790° E



### КРИСТАЛ ЛОУНЖ

📍 Завхан аймгийн  
Улиастай хот

☎ 99461190

📌 Монгол, Европ, хүргэлт  
<https://zavkhan.travel>

📏 хүрэв.хойтон.буурь  
46.2729° N, 102.7790° E

# ЭВЭНТ БАЯР НААДМУУД

## НҮҮДЭЛЧДИЙН СОЁЛЫН НААДАМ

Гадаад дотоодын жуулчдын сонирхлыг татах нүүдэлчдийнхээ соёл, өв уламжлалыг харуулсан төрөл бүрийн отгуудыг байгуулдаг. Түүнчлэн уран уургач, бугуйлч, эмнэг булгиачдын уралдаан, монгол ахуй монгол заншлыг бодитоор харуулдаг ажээ.

### **ХУГАЦАА:**

Жил бүрийн 7-р сарын 20-оос 23-ны өдөр

### **ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР:**

Эрдэнэхайрхан сум, Хар нуурын өмнө эрэг

### **ХӨТӨЛБӨР:**

- Багийн тэмцээн
- Хөгжимт жүжгийн театр
- Дүүгүүр шидэх
- Уургач бугуйлчдын тэмцээн
- Хос морь шалгаруулах тэмцээн
- Эсгий хийх тэмцээн
- Хурдан морины уралдаан
- Нүүдэлчин ахуй соёлтой танилцах



## АЯЛЛЫН МАРШРУТ 2

Байгалийн өвөрмөц тогтоц бүхий говийн тусгай сонирхлын аялал

Аяллын эхний цэг:

Завхан аймгийн Улиастай хотоос эхэлнэ.

- Улиастай хотоос Хар нуур жуулчны баазад ирж хоноглох. Туулах зам 120км
- Хар нуураас Холбоо нуур, Баян нуурыг үзэн сонирхон хоноглох буцаж Хар нуур жуулчны баазад ирэх. Туулах зам 170км /элсний сүвээр/ 250км /цагаан замаар/
- Хар нуураас Сэнжит цохио, Их, бага хатавчийн ам, Мухартын үдлэх цэгт очно. Туулах зам 50км
- Мухартаас сээрийн дөрөлжөөр давж, Донойн хөндий, Яруугийн хүрээг үзэн Улиастайд ирж Их монгол жуулчны баазад хоноглох. Туулах зам 120км

Нийт туулах зам:460

Нийт аяллын хоног:4



## АЯЛЛЫН МАРШРУТ 1

Байгалийн өвөрмөц тогтоц бүхий хангайн тусгай сонирхлын аялал

Аяллын эхний цэг:

Завхан аймгийн Улиастай хотоос эхэлнэ.

- Улиастай хотоос Хатавчийн амны хүн чулуун хөшөө Загастай даваа Идэр сумын төв Ногоон нуур дахь Маргад эмбүү жуулчны баазад хоноглох. Туулах зам 95 км
  - Цагаан нуур, Тахилтын хүрхрээ, Идэр сумын төв Тун, Жаргалангийн гол, Бөхөн шарын даваа Тэгшийн голын үдлэх цэг. Туулах зам 60км
  - Тэгшийн голоос Баяжихын даваа Хангайн нурууны Марз уул, Хожуулын рашаан сувиллын газар хоноглох. Туулах зам 70км
  - Хожуулын голоос уруудан байгалийн үзэсгэлэнт газраар аялан хожуулын голын жуулчны баазад амрах. Туулах зам 70 км
  - Тосонцэнгэл сумтай танилцах аялал. Туулах зам 15км
  - Тосонцэнгэл сумаас Мэргэний даваа даваад Тэлмэн нуур, Долоон товгор элсэн манхан Ангирт нуурын хөвөөнд орших Замбага жуулчны баазад амрах. Туулах зам 80км
- Нийт туулах зам:390  
Нийт аяллын хоног:4



## АЯЛЛЫН МАРШРУТ 3

Хангай нурууны ноён оргил Отгонтэнгэр /4021м/ уул, Их монгол элсэн манхан, тал хээрийн бүсийг багтаасан аялал

Аяллын эхний цэг:

Завхан аймгийн Улиастай хотоос эхэлнэ.

- Улиастай хотоос Богдын гол Мөнгөт хясаа, Богдын голын хүрхрээ, Цагаан нуур, Даян ууланд Вансэмбэрүү цэцэг үзэх, Отгонтэнгэрийн рашаан сувиллын газар хоноглох. Туулах зам 50км
  - Отгонтэнгэрийн рашаан сувиллын газраас Долоогийн даваа, Отгон сум Буянт багаар дайран Отгонтэнгэр уулын өвөрт ирж Отгон Буянт Хангай жуулчны баазад хоноглох. Туулах зам 120км
  - Отгонтэнгэрээс Отгон сум, Шилүүстэй сумын Дааган дэлийн буган чулуун хөшөөний үдлэх цэг, Цагаанхайрхан сумын онц хайрхан Монгол элсний эх, Ширээгийн гол, Энхийн хясааны үдлэх цэг. Туулах зам 150км
  - Энхийн хясаанаас Поврон, Борхын шугуй Завхан голоор гаран Эрээн нуур жуулчны баазад хоноглох. Туулах зам 100км
  - Эрээн нуур Завхан голын Далтын гарам, Тэсийн бүрдийн чацарганын шугуй, Их хайрхан уул, Их агуй. Туулах зам 100км
  - Ханын хүдгийн хясаа, Ямаан усны үдлэх цэг, Алдархаан сум, Улиастай хотод ирж хоноглох. Туулах цэг 130
- Нийт туулах зам:650  
Нийт аяллын хоног:6



# ЗАВХАН АЙМГИЙН АЯЛЛЫН МАРШРУТ